



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 02 дугаар сарын 07 өдөр

Дугаар 09

Хэрлэн сум

Аймгийн Онцгой комиссын IX хуралдааныг 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 11:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 27 гишүүд оролцохоос 23 гишүүнтэй 85% ирцтэй хуралдав.

Хурлыг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Шинэ коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, нөхцөл байдлын талаар Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаагийн мэдээллийг сонсох;

2. "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-аас Дорнод аймгийн Онцгой комисст ирүүлсэн Газрын тосны тээвэрлэлтийг хэвийн явуулах тухай хүсэлтийг хэлэлцэв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

1. Баянхошуу боомтод ариутгал, халдваргүйтгэл хийх нөхцөл, шаардлага бүрэн хангагдаагүй, хүйтний улиралд автомашиныг автомаксаар ариутгахад шингэн бодис хөлдөх, бодисын чанар алдагдах, 1 автомашинд зарцуулах хугацаа их зэрэг хүндрэлүүд үүсэж байгаатай холбогдуулан хилийн Баянхошуу-Өвдөг боомтод Олон улсын стандартын шаардлага хангасан ариутгал, халдваргүйтгэлийн пунктыг "Петрочайна Дачин Тамсаг" ХХК-аар бариулах, тухайн компаниас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг сайжруулсан тохиолдолд газрын тосны тээвэрлэлтийг явуулах;

2. Дээрх шийдвэрийг хэрэгжүүлээгүй тохиолдолд 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл газрын тосны тээвэрлэлтийг зогсоох шийдвэрийг 100 хувийн саналаар дэмжсэн.

Бүсийн төв-Дорнод аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандахад:

1. Улсын Онцгой комиссын 03 дугаар хуралдаанаас баталсан Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөөтэй уялдуулан Онцгой комиссын гишүүд, холбогдох мэргэжлийн

байгууллагуудын саналыг авч салбар дундын төлөвлөгөө боловсруулж танилцуулахыг;


Цагдаагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандаа Т.Ганзоригт:

1. Дорнод аймгийн хэмжээнд баар, ресторан, үйлчилгээний газруудын цагийн хязгаарлалтад онцгойлон хяналт тавьж, цагийн хязгаарлалтыг зөрчсөн тохиолдолд тусгай зөвшөөрлийг цуцлах хүртэл арга хэмжээ авч ажиллахыг;

Боловсрол, соёл урлагийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн А.Нансалмаа, Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийн газрын дарга Э.Жавхлан, Сумын Засаг дарга нарт:

1.Цэцэрлэг, сургуулийн үйл ажиллагаа хаасантай холбогдуулан бага насны хүүхдийг гэртээ харгалзах хүнгүйгээр орхидог байдалд хяналт тавьж, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ, ОНЦГОЙ КОМИССЫН  
ОРЛОГЧ ДАРГА  Ч.ГАНБАТ

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА, ДЭД ХУРАНДАА  Д.БАТТУЛГА